



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 03-р сарын 09-ний өдөр

№ А/01

Улаанбаатар хот

*Компаниас олон нийтэд санал болгон нэмж гаргах энгийн хувьцаанаас  
Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид  
худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай*

“Инвескор ББСБ” ХК (“Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.5, 2.7 дахь хэсэг, “Инвескор ББСБ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.3, 9.6.23 дахь заалтууд, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Тооллогын комиссын шийдвэрийг тус тус ҮНДЭСЛЭН,

- I. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 04-р сарын 24-ний өдрийн 70 тоот тогтоолд заасан шаардлагын хүрээнд болон Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг яаралтай нэмэгдүүлэх зорилгоор “Инвескор ББСБ” ХК-ийн зарласан хувьцааны тоонд багтаан Компанийн энгийн хувьцааны 12.5 хүртэлх хувийн хувьцааг үе шаттайгаар нэмж гаргах шаардлагатайг болон,
- II. Компанийн тухай хуулийн 34-р зүйлийн 34.2, 38-р зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй бөгөөд 38-р зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх санал өгсөн болохыг Тооллогын комисс тогтоосон болохыг ТЭМДЭГЛЭН,

**ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, Компанийн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагад үндэслэн хувьцаа нэмж гаргах ажиллагааг оновчтой зохион байгуулах хүрээнд Компанийн энгийн хувьцааны 12.5 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг нэмж гаргахад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн дүрэмд заасан зарласан хувьцаанаас нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, үе шаттайгаар нийтэд санал болгох хугацааг тодорхойлох зэрэг хувьцаа нэмж гаргахтай холбогдох бусад шийдвэрийг тухай бүр гаргаж, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болохыг дурдсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллан, ажлын үр дүнг танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д тус тус даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА**

